

**“НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР” ОНӨААТҮГ-ЫН
АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ
(жилийн эцэс)**

2025 оны 12 дугаар сарын 12

Улаанбаатар хот

Д/д	Зорилго	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Зардал (төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа	Биелэлт	Хувь
1	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх	1.1.Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (сошиал сувгууд), мөн сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэсэн байх;	-Баримтжуулсан байх; -Үр дүнг тооцож, тайлагнасан байх; (түгээсэн тоо, давтамж, авсан хандалтын тоо) -Хэлтсүүдийг хамруулсан байна;	-	Тухай бүр	Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн тв, нийтлэл, шторк, зурагт хуудас зэрэг мэдээллийг албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ, мэдээллийн самбарт тухай бүр байршуулан олон нийтэд хүргэв. ➤ шторк 2025 оны 06 сарын 18-ны өдрийн “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтнуудад зориулсан гарын авлага”-ыг шинэчлэн хэвлүүлээ мэдээлэл 5-лайк, 1-шэйр, 148-хандалт, ➤ 2025 оны 10 дугаар сарын 05-ны өдөр “Авлига гэж юу вэ” сэдэвт видео шторкыг байгууллагын вэбхуудсанд, ➤ 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдөр “ХАСХОМ хэрхэн баталгаажуулах вэ” сэдэвт видео шторкыг байгууллагын вэбхуудсанд, ➤ 4.2025 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр “Авлигыг хэрхэн мэдээлэх вэ” сэдэвт видео шторкыг байгууллагын вэбхуудсанд тус тус нийтлэв. Холбогдох нотломжийг хавсаргав.	100 хувь
		1.2.Газрын үйл ажиллагаанд авлигад өртөж болзошгүй чиглэлийг сонгон авлигын эрсдэлээс	-2-оос доошгүй соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулсан байх;	50.000	Жилдээ	Өөрийн байгууллагын үйл ажиллагаатай уялдуулан авлига ашиг сонирхлоос ангид байх, холбогдох дүрэм, журам, стандартыг мөрдөж ажиллах, ажлын сахилга хариуцлагыг сайжруулан	90 хувь

	ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий арга хэмжээг зохион байгуулах, түгээх;	-Үр дүнг тооцож, нотломжийг хавсаргасан байна;			ажиллах талаарх агуулга бүхий мэдээллийг НХОГ дотоод сүлжээнд байршуулав. Мөн Газрын цахим хуудсаар дамжуулан "Авлига, ашиг сонирхлыг мэдээлэх утас 110" сэдэвт 14 сурталчилгааны постер бэлтгэн олон нийтэд түгээв. Холбогдох зардал гараагүй болно.	
	1.3.Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах "Шударга ёс, хөгжил дэвшилд 110" мэдээллийн самбар ажиллуулах;	-Мэдээллийг сар бүр шинэчлэн ажилласан байна; -Тайланд сар бүр шинэчилсэн нотломжийг хавсаргасан байна;	-	Тухай бүр	Газрын цахим invest.ub.gov.mn хуудас, мэдээллийн самбар, erp.ulaanbaatar.mn системээр дамжуулан "Авилга, ашиг сонирхлыг мэдээлэх утас 110" сэдэвт 14 суртчилгааны постер бэлтгэн олон нийтэд түгээв.	100 хувь
	1.4.Газрын үйл ажиллагааг авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий (шторк, зурагт хуудас, сонины нийтлэл, радио контент, цахим, хэвлэмэл ном, гарын авлага, броюшур зэргээс боломжит хэлбэрийг сонгон) сурталчилгааг хийж олон нийтэд хүргэсэн байх;	-2-оос доошгүй сурталчилгааны материал боловсруулсан байна; -Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (сошиал сувгууд), мөн сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон	-	Жилдээ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас бэлтгэн хэвлэсэн зурагт мэдээллийг дотоод мэдээллийн самбарт байршуулан ажиллав. Албан хаагчдын ёс зүй, ёс суртахууны тухай мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх зорилготой "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль", "Газрын ёс зүйн дүрэм", Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр (2024-2030)", Нийслэлийн Засаг даргын 2025 оны "Сахилга хариуцлага, төрийн үйлчилгээг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай" А/62 дугаар захирамж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны 03/2617 дугаарын албан бичгээр Нийслэлийн нутгийн захиргааны харьяа байгууллагын нийт албан хаагч нарт холбогдох хууль тогтоомжийн хүрээнд Ажлын байранд дээрх ёс зүйн хэм, хэмжээг мөрдөж ажиллахыг анхааруулсан тухай мэдэгдэл	100 хувь

			хэлбэрээр олон нийтэд хүргэсэн байна; -Авлигыг мэдээлэх 110 дугаарыг оруулсан байна;			дээрх ёс зүйн хэм, хэмжээг мөрдөж ажиллахыг анхааруулсан тухай мэдэгдэл болон Академич, доктор профессор, хуульч С.Нарангэрэлийн "Ёс суртахуун, ёс зүйн" талаар өгсөн мэдээллийг тус тус постер байдлаар бэлтгэн нийт 6 удаа дотоод сүлжээнд байршуулан албан хаагчдад мэдээлэл хүргэсэн. Холбогдох мэдээллийг газрын https://invest.ub.gov.mn/ сайтад байршуулав.	
2	Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, сургалтад хамруулах	2.1.Ажил, албан тушаалд шинээр томилогдсон албан хаагчдыг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ёс зүйн сургалтад бүрэн хамруулсан байна; -Тайланд нотломжийг хавсаргасан байна;	-Шинэ томилогдсон албан хаагчдыг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ёс зүйн сургалтад бүрэн хамруулсан байна; -Тайланд нотломжийг хавсаргасан байна;	-	Жилдээ	“Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын Авлигын эсрэг үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөөг газрын даргаар 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдөр батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөний хүрээнд авлига, албан тушаалын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр дараах сургалт зохион байгуулагдав. Үүнд: 1.2025 оны 06 дугаар сарын 19-ний өдөр “Ашиг сонирхол ба нөлөөлөх хүчин зүйл” сэдэвт сургалтад 50 албан хаагч, 2.2025 оны 09 дүгээр сарын 24-ний өдөр “Авлига, ашиг сонирхол, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтад 84 албан хаагч, 3.2025 оны 10 дугаар сарын 17-ны өдөр “Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонихлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” сэдэвт сургалтад 68 албан хаагч тус тус хамрагдав.	100 хувь
		2.2.Тухайн байгууллагын				Газрын 2025 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг	

		ажилладаг (тухайлбал, тусгай зөвшөөрөл эзэмшигч, итгэмжлэгдсэн төлөөлөгч, хамтран ажилладаг бизнесийн байгууллага, үйлчилгээ авдаг хуулийн этгээд, иргэн, хяналт, оролцоо хэрэгжүүлдэг ТББ г.м) байгууллагад авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг сайжруулах, ёс зүйг дээшлүүлэх, үйл ажиллагааны хүнд суртлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, түүний үр дүнг мэдээлэх сурталчлах арга хэмжээг зохион байгуулах;	тулгуурлан зохион байгуулсан байна; -Тайланд нотломжийг хавсаргасан байна;	-		зүйг дээшлүүлэх чиглэлээр гүйцэтгэгч байгууллагын төлөөллөөс сэтгэл ханамжийн судалгааны асуумж тогтмол авч байна. Тайлант хугацаанд төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж иргэдэд төрийн үйлчилгээг шуурхай үзүүлэхэд гарсан хүндрэл бэрхшээл, гомдол гараагүй. Газрын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж, хүнд суртлыг багасгах, авлига үүсэх эрсдэлийг бууруулах чиглэлээр санал асуулгыг цахим хэлбэрт шилжүүлэн, QR кодоор судалгааг санал асуулгын https://jotform.com сайтыг ашиглаж, мэдээллийг тогтмол цуглуулан ажиллаж байна.	100 хувь
3	Авлигын эсрэг үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох	3.1.Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх;	-Байгуулсан бүх гэрээнд авлигаас ангид байх асуудлыг тусгасан байна; -Авлигыг мэдээлэх үүргийг тусгасан байна; -Гэрээг цуцалсан тохиолдолд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг оруулах; -Хэрэгжилтийн ач холбогдлыг үнэлж, дүгнэсэн байна;	-	Жилдээ	Хөдөлмөрийн "дотоод журам"-ын 4.20 дэх хэсэгт "Газрын үйл ажиллагааг хэвийн явуулах зорилгоор шаардлагатай тохиолдолд төлөвлөгөөнд тусгасан цалингийн санд багтаан гэрээгээр иргэнийг авч ажиллуулж болно" гэж заасны дагуу иргэнтэй байгуулж буй гэрээнд авлигаас урьдчилан сэргийлэх талаар дараах заалтыг тусган ажиллаж байна. Иргэнтэй байгуулсан гэрээний 4.5 дахь заалтад "Авлигын эсрэг хуульд заасан авлигатай холбогдсон талаар бодит мэдээлэл байгаа бол холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад зохих ёсоор мэдэгдэх үүрэгтэй" тусган гэрээлэв.	100 хувь

			-Тайланд нотломжийг хавсаргасан байна;			Тайлант хугацаанд Хамтран ажиллах гэрээний үндсэн дээр ажиллаж байгаа 3 иргэн байна.	
		3.2.“Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ын хүрээнд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлуулах, хэрэгжүүлэх;	-Газрын даргаар төлөвлөгөө батлуулан ажилласан байна; -Олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэн тайлагнасан байна;	-	Жилдээ	Газрын даргаар 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдөр Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 109 дүгээр тогтоол “Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ын хүрээнд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөний хэрэгжилт хагас жилийн байдлаар буюу 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар 97,1 хувийн гүйцэтгэлтэй, жилийн эцсийн байдлаар буюу 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн байдлаар 98,5 хувийн гүйцэтгэлтэйгээр тус тус Захиргааны хэлтсийн дарга болон Газрын даргад тайлагнав.	97,8 хувь
4	Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах	4.1.Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх (үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж, асуудлыг шийдвэрлүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийлгэх г.м;	-Үйл ажиллагаанд эрсдэлийг тодорхойлж, урьдчилан сэргийлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, үр дүнг тооцсон байна; -Тайланд нотломжийг хавсаргасан байна;	-	Жилдээ	Газраас гүйцэтгэгчид үзүүлж буй дараах үйлчилгээ буюу: -Барьцаа хөрөнгө чөлөөлөх -Барилга угсралтын ажлын гүйцэтгэл -Зураг төслийн ажлын гүйцэтгэл ... олгоход шаардагддаг нэхэмжлэхийг цаг алдалгүй байгаа газраас нь цахимаар QR код бүхий И-нэмэмжлэх үүсгүүлэн хүлээн авч төрийн үйлчилгээний шат дамжлагыг бууруулан үйлчилгээг цахимжуулан ажиллаж байна.	100 хувь

	4.2.Газрын хэмжээнд авлигаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг тодорхойлох, хүнд суртлыг бууруулах чиглэлээр хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулж, шалтгаан нөхцөлийг арилгасан байх;	-2-оос доошгүйг зохион байгуулсан байна; -Хэлэлцүүлэг, уулзалтын үр дүнд арга хэмжээ зохион байгуулсан байна; -Тайланд нотломжийг хавсаргасан байна;	50.000	Жилдээ	Газрын даргын 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн А/70 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ-ын Авлигын эсрэг үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулан ажилтан, албан хаагчдаас 2025 оны 11 дүгээр сарын 03, 04-ний өдрүүдэд "Авлигаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг тодорхойлох судалгаа"-г google forms.monday.com авч, үр дүнг нэгтгэн хэлтсийн даргад танилцуулав. Тус судалгааны үр дүнд ажилтан, албан хаагчид холбогдох сургалтад танхим болон цахимаар хамрагдсан, газрын хэмжээнд таны эрхэлж буй ажил, албан үүрэгтэй холбоотой авлигын ямар нэг тохиолдолд гарч байгаагүй гэж 96 хувь нь, үзсэн бол ажил үүргээ гүйцэтгэж байх үедээ авлигаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллаж чаддаг гэж мөн 96 хувь нь хариулсан байв. Судалгаанд салбарын авлигын талаарх асуудлын эрсдэлийг дундаж, салбарын хэмжээнд авлигаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг тодорхойлох хүнд суртлыг бууруулах чиглэлээр хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулах шаардлагагүй, харин ийм арга хэмжээ зохион байгуулагдах тохиолдолд оролцох боломжтой гэж 50 хувь нь хариулсан байв. Судалгаанд хамагдсан нийт ажилтан, албан хаагчид авлигын талаар мэдлэг, мэдээлэлтэй гэж хариулсан байв.	70 хувь
	4.3.Үйлчлүүлэгчдээс авлигын эрсдэл, үйл ажиллагааны хүндрэл бэрхшээлийг тодорхойлох сэтгэл	-Бодитой үр дүнг тооцсон байна;	-	Жилдээ	Тайлант хугацаанд төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж иргэдэд төрийн үйлчилгээг шуурхай, хүнд сурталгүй үзүүлэхтэй холбоотой гарсан хүндрэл бэрхшээл, гомдол гараагүй.	100 хувь

		ханамжийн судалгаа авч, судалгааны дүгнэлтэд тулгуурлаж арга хэмжээ зохион байгуулах байх;	-Тайланд нотломжийг хавсаргасан байна;			Гүйцэтгэгч байгууллагуудад тухай бүр түргэн шуурхай үйлчилж байна. Газрын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж, хүнд суртлыг багасгах, авлига үүсэх эрсдэлийг бууруулах чиглэлээр тогтмол санал асуулга авч ажиллаж байна.	
5	Ил тод байдлыг сайжруулах, хүнд суртал, чирэгдлийг бууруулах, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх	5.1.Төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн талаарх мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлэн ажиллах 5.2.Газрын хэмжээнд хяналт тавин хэрэгжиж буй улс, нийслэл, орон нутаг, гадаадын төсөл хөтөлбөр, дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа барилга угсралт, тохижилт, инженерийн шугам сүлжээ, барилга байгууламжийн хэсэгчилсэн болон их засварын ажил буюу бүтээн байгуулалтын ажлын явцын мэдээллийг UB.NVEST аппликэйшнээр дамжуулан олон нийтэд мэдээлж ажиллах;	-Газрын вэб сайтад төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн талаарх мэдээллийг байршуулан ажилласан байна -Ажлын үр дүнг нээлттэй мэдээллэн ажилласан байна	-	Жилдээ	Тайлант хугацаанд манай газраар хэрэгжиж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн талаар мэдээллийг http://invest.ub.gov.mn/ цахим хуудсанд 108 удаа иргэд, олон нийтэд тогтмол нээлттэй нийтлэн түгээж ажиллав.	100 хувь
				-	Тухай бүр	Манай газраар хяналт тавин хэрэгжиж буй улс, нийслэл, орон нутаг, гадаадын төсөл хөтөлбөр, дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа барилга угсралт, тохижилт, инженерийн шугам сүлжээ, барилга байгууламжийн хэсэгчилсэн болон их засварын ажил буюу бүтээн байгуулалтын ажлын явцтай танилцаж мэдээлэл авах боломжтой UBINVEST аппликэйшныг олон нийтэд түгээн ажиллаж байна.	100 хувь

		5.3.Улс, орон нутгийн, гадаадын зээл, тусламжаар санхүүжүүлж байгаа төсөл, арга хэмжээний мэдээллийг иргэд, олон нийтэд ил тод, нээлттэй болгох;	-Стандарт, хэмжил зүйн газрын даргын2023 оны с/49 тушаалаар батлагдсан MNS 7023:2023 стандартыг хэрэгжилтийг хангуулан ажилласан байна	-	Жилдээ	Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн с/49 дүгээр Үндэсний стандарт шинээр батлах тухай тушаалын дагуу 2025 оны жилийн эцсийн байдлаар байдлаар Техникийн хяналт тавин хэрэгжүүлж байгаа мэдээллийн самбар байршуулах 251 төсөл арга, хэмжээнээс зогссон 54, ажил эхлээгүй 55, самбар байршуулаагүй 22, байршуулсан 120 төсөл, арга хэмжээ байна. Нийт байршуулах шаардлагатай төсөл, арга хэмжээний 85 хувьд самбарыг байршуулсан байна. Ажлын гүйцэтгэл 100 хувьтай тус стандартын хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.	100 хувь
БУСАД НЭМЭЛТ АЖИЛ							
6	Нэмэлт ажил	6.1.Газрын дүрмээр хүлээсэн үүргийн биелэлтэд Хууль, дотоод хяналтын хэлтэс хяналт-шинжилгээ, үнэлгээг тогтмол хийх;	-хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ хийсэн байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх;	-	Жилдээ	Газрын дотоод зохион байгуулалтыг ханган Хууль, дотоод хяналтын хэлтэс нь дүрмээр хүлээсэн үүргийн биелэлтэд 2025 оны хагас жил, жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ үнэлгээ хийж ажиллав.	100 хувь
		6.2.Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас гаргаж байгаа өргөдөл, гомдлыг хүлээн авах эх үүсвэрийг нэмэгдүүлж, шийдвэрлэлтийн чанар, үр дүнг сайжруулах;	-Өргөдөл, гомдлыг хүлээн авах эх үүсвэрийг нэмэгдүүлэн ажилласан байна -Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн чанар, үр дүнг сайжруулан ажилласан байх;	-	Жилдээ	Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг ub.epr.ulaanbaatar.mn системээс гадна Нийслэлийн Засаг даргын 2022 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн А/1049 дугаар захирамжийн дагуу холбогдох эх үүсвэрийг нэмэгдүүлэн ажиллав. Газрын “Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө”-г 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр Газрын даргаар батлуулж, төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж, төлөвлөгөөний биелэлт, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн тайланг Газрын даргын	97 хувь

					зөвлөлийн хурлын тэмдэглэлээр албажуулан, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвд тухай бүр тогтоосон хугацаанд хүргүүлэн ажилласан. Үүнд: ➤ 1 дүгээр улирлын тайланг 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр 01/1203 дугаар албан бичгээр, ➤ Хагас жилийн тайланг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдөр 01/2644 дугаар албан бичгээр, ➤ 3 дугаар улирлын тайланг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 01/4128 дугаар албан бичгээр тус тус хүргүүлэв. 2025 оны жилийн эцсийн тайланг 2025 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн дотор Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвд хүргүүлэхээр ажиллаж байна. 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн байдлаар Erp.Ulaanbaatar.mn өргөдөл, гомдлын программд нийт 178 өргөдөл, гомдол бүртгэгдсэн. Үүнд: иргэнээс 160, албан хаагчаас 18 өргөдөл, гомдол бүртгэгдсэн ба хугацаандаа шийдвэрлэгдсэн 173 буюу 97 хувь, судлагдаж байгаа 4 буюу 2 хувь, хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн 1 буюу өргөдөл, гомдол байна. Өргөдөл, гомдлыг шийдвэрлэх явцад 9 зөрчил бүртгэгдсэн. Үүнд: ➤ Өдөрт нь багтаан шилжүүлээгүй 2 ➤ Өдөрт нь багтаан хүлээн аваагүй 3 ➤ Явцын тэмдэглэл хөтлөөгүй-4 Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 13 хоног 7 цаг 43 минут байна.	
--	--	--	--	--	--	--

	6.3.Худалдан авах ажиллагааны АЗ сургалтад хамрагдах албан хаагчийн тоог нэмэгдүүлэх;	-Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо нэмэгдүүлэн ажилласан байна (танхим, цахим)	-	Жилдээ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх АЗ шалгалтыг Төрийн худалдан авах ажиллагааны газартай хамтран зохион байгуулж, худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтны сургалтын үр дүнд 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн байдлаар АЗ гэрчилгээтэй 85 албан хаагч байна.	100 хувь
	6.4.Газрын төсөв, санхүүгийн сахилга, батыг сайжруулах;	-Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна	-	Жилдээ	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн А/921 дүгээр захирамжаар Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын Эдийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшинг 2025 онд 10,081,057.24 мянган төгрөгийн орлоготой, 9,732,571.83 мянган төгрөгийн зардалтай, 313,636.87 мянган төгрөгийн цэвэр ашигтай байхаар баталсан. Жилийн эцсийн урьдчилсан байдлаар 11,586,576.90 мянган төгрөгийн орлоготой, 8,862,519.00 мянган төгрөгийн зардалтай, 2,456,652.11 мянган төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажиллаж байна. 2025 онд орлогын төлөвлөгөөг 1,505,519.66 мянган төгрөгөөр давуулан биелүүлж, зардлыг нийт 870,052.83 мянган төгрөгөөр хэмнэн ажилласан. 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн байдлаар өссөн дүнгээр улс, нийслэлийн төсөв болон нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд нийт 306.7 тэрбум төгрөгийн санхүүжилтыг байгууллагын төрийн сан дах 100200051300 тоот дансаар дамжуулан олгосон байна. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж мэдээллийг тухай бүр нь байршуулан нээлттэй ил тод ажиллаж	100 хувь

					байна. 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн байдлаар 5 сая төгрөгөөс дээш орлогын 450 ажил гүйлгээний 580.2 тэрбум төгрөг, зардлын 421 ажил гүйлгээний 597.7 тэрбум төгрөгийн санхүүжилтийн мэдээг тухайн сар бүр хуульд заасан хугацаанд www.shilendans.gov.mn (https://www.shilendans.gov.mn/) сайтад бүртгэж байршуулсан. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа 416 төсөл арга хэмжээний (давхардсан тоогоор) 285.4 тэрбум төгрөгийн санхүүжилтыг Сангийн яамны https://pimis.publicinvestment.gov.mn/ сайтаар дамжин хянан баталгаажуулж, санхүүжилт олгосон байна.
Дундаж хувь 97,6					

ТАНИЛЦСАН:
ГАЗРЫН ДАРГА

ХЯНАСАН:

ЗАХИРГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГА

НЭГТГЭСЭН:

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Б.МӨНХБАТ

Ц.ГҮРБАДАМ

А.СОЛОНГО